



Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Олимпийн гудамж-4
Нью Хоризонс 201

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

2022.08.15 № 24/607

Танай _____-ны № _____

Харилцан холболтын гэрээний нөхцөл хүргүүлэх тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооноос мэдээлэл холбооны үйлчилгээ эрхлэгчдийн харилцан холболт хийх гэрээний нөхцөл /RIO/-г боловсруулах жишиг бичиг баримтыг 05/1055 тоот албан бичгээр манай манай компанид ирүүлсний дагуу Ондо ХХК-ийн Харилцан холболтын гэрээний нөхцөл /RIO/-г жишиг бичиг баримтад нийцүүлэн шинэчлэн баталж хүргүүлж байна.

Хавсралт:

1. Ондо ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн А/30 дугаар тушаал;
2. Ондо ХХК-ийн 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Харилцан холболт хийх гэрээний нөхцөл".

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.АНАР



**“ОНДО” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 8-р сарын 12-ны өдөр

A/30

Улаанбаатар хот

Харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл /RIO/ батлах тухай

Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл /RIO/-г шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хавсралтыг компанийн цахим сайтад байршуулах замаар олон нийтэд мэдээлэхийг Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал (Б.Мандуул)-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Ондо ХХК-ний Гүйцэтгэх захирлын 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаал, 2022 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн А/28 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.АНАР

Ондо ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 8 дугаар сарын 12-ны
өдрийн тушаалын 1-р хавсралт



ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ (RIO¹)

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын (цаашид “журам” гэх) 2.3² дахь хэсэгт зааснаар харилцаа холбооны үйлчлэгч нь Харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (цаашид “нөхцөл” гэх) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж, өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, цахим хуудастаа байршуулах үүрэгтэй.
- 1.2. Энэхүү сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлөөр Ондо ХХК болон тусгай зөвшөөрөл бүхий сүлжээ хооронд, харилцан холболт хийхээр хүсэлт гаргагч нарын сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, зааглах цэгийн байршил, гэрээ байгуулах, сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчлэгчтэй сүлжээнд холбогдох гэрээ байгуулахдаа хууль, журам болон энэхүү нөхцөлд заасан хэм хэмжээг мөрдөнө.
- 1.4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь “Харилцан холболт”-ын гэрээ байгуулахад дараах зарчмыг баримтална.
 - 1.4.1. Үл ялгаварлах;
 - 1.4.2. Технологийн бус шалтгаанаар харилцан холболт хийхээс үл татгалзах;
 - 1.4.3. Нээлттэй ил тод байх.

2. ХОЁР. НЭР ТОМЬЁО

- 2.1. “Сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөл” гэж “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.3² дахь хэсэгт заасан мэдээллийг агуулсан баримт бичгийг ойлгоно.

¹ Reference Interconnection Offer, Энэхүү баримт бичгийн 2.3 дэх хэсгийг харна уу.

² 2.3 Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (RIO^[1]) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж, өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд:

- 2.3.1. Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага;
- 2.3.2. Зааглах цэгийн байршил;
- 2.3.3. Сүлжээнд харилцан холболт хийх төлбөр тооцооны мэдээлэл;
- 2.3.4. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;
- 2.3.5. Гэрээний загвар.

- 2.2. “Харилцаа холбооны үйлчлэгч” гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16³-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.
- 2.3. “Зааглах цэг” гэж Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар Үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг ойлгоно.
- 2.4. “Телефон ярианы үйлчилгээ гэдэгт” гэж Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага (Телефон ярианы үйлчилгээнд)-ын 1.3-т заасан үүрэн болон суурин (яриа, мессэж, дата үйлчилгээ) эрхлэхээр авсан иргэн хуулийн этгээдийг ойлгоно.

3. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ, ГОРИМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 3.1. Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага болон өөрийн сүлжээний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах техникийн нарийвчилсан нөхцөлийг хууль тогтоомж, Зохицуулах хорооны шийдвэр, зохицуулалт, журам, нөхцөл шаардлагад нийцүүлэн боловсруулж энэхүү зүйлд нарийвчлан тусгана.
- 3.2. Хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан холболтын байгууламжтай байна. Үүнд:
 - 3.2.1. Сүлжээний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангасан байх;
 - 3.2.2. Ярианы болон бусад холбогдох протоколууд ба кодыг дэмжих, тэдгээрийн хуваарилалт шилжилтийг хийдэг байх;
 - 3.2.3. Ярианы төлбөрийг секундын нарийвчлалтай хийдэг байх;
 - 3.2.4. Бусад сүлжээтэй ITU-T стандартуудын дагуу холбох шугамаар холбогдох боломжтой байх
- 3.3. Энэхүү нөхцөлийн 3.2 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийг сүлжээндээ холбохоос татгалзаж болно. Энэ тохиолдолд журмын 3.2 дахь хэсэгт заасан хугацаанд, 3.3 дахь хэсэгт заасан тайлбарыг албан бичгээр мэдэгдэнэ.
- 3.4. Харилцаа холбооны үйлчлэгч нь энэхүү нөхцөлд тусгагдсан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагаас өөр нөхцөлийг телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд тавихгүй.
- 3.5. Зохицуулах хороо харилцаа холбооны үйлчлэгч өөрийн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг тогтооход газар дээр нь хэмжилт, шалгалт хийж болно.
- 3.6. Ондо ХХК нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн техникийн боломжийг харгалзан өөрийн сүлжээнд бусад сүлжээг саадгүй холбох нөхцөлийг хангаж ажиллана.
- 3.7. Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж,

³ 15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;
15.16.2. харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;
15.16.3. контентийн үйлчилгээ эрхлэх;
15.16.4. тоон гарын үсгийн гэрчилгээ олгох.
15.16.5. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
15.16.6. радио, телевизийн үйлчилгээ;
15.16.7. олон суваг дамжуулах үйлчилгээ.

- багтаамж, тоо ширхэг зэргийг гэрээний хавсралтаар заах бөгөөд өөрчлөлтүүдийг тухай бүр тусгаж байна.
- 3.8. Сүлжээ хоорондын дохиолол нь SIP байна.
- 3.9. Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.
- 3.10. **Сүлжээний ачаалал**
- 3.10.1. Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
- 3.10.2. Нэгж шугамд ноогдох ачааллын хэмжээг 0.65 Эрлангаас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.10.3. Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талуудын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг 3 сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.11. **Сүлжээний дугаарлалт**
- 3.11.1. Талуудын сүлжээний дугаарлалт нь Зохицуулах хорооноос олгогдсон дугаарлалтын хүрээнд байна.
- 3.11.2. Талууд сүлжээний дугаар шинээр үүсгэх тохиолдолд нөгөө талдаа ажлын 5 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 3.11.3. Хүсэлт гаргагч нь орох дуудлагын хувьд ОУЦХБ-ын Е.164-ийн дагуу дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулдаг (CLI- Call line identification) байна. Энэ нь улс хооронд болон улс доторх ярианд ижил хамаарна.
- 3.12. Харилцаа холбооны үйлчлэгч нь энэхүү хавралтын 1 дэх хэсэг заанаас бусад шалтгаанаар харилцан холболт хийхээс үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй.
- 3.13. Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл авснаас хойш 3 сарын дотор холболтоо хийж үйлчилгээгээ эхлэх үүрэгтэй.
- 3.14. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь техникийн нөхцөлөө авснаас хойш 3 сарын дотор холболтоо хийж эхлээгүй бол дахин техникийн нөхцөлийг илгээх бөгөөд энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэнэ.
- 3.15. Сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх горимд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлийг аль нэг тал нь санаачлан хийх бол 3 сараас доошгүй хугацааны өмнө өөрчлөлт хийх талаарх мэдээлэл, үндэслэл, шаардагдах техникийн нөхцөлийг бусад харилцаа холбооны үйлчлэгчдэд мэдэгдэн тохиролцох ба энэ талаар Зохицуулах хороо-нд нэн дариу мэдэгдэнэ.

4. ДӨРӨВ. ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

- 4.1. Харилцаа холбооны үйлчлэгч нь зааглах цэгийн байршлыг аль нэг үйлчилгээ эрхлэгчийн сүлжээний эсхүл дамжуулах төхөөрөмжөөр тогтооно.
- 4.2. Зааглах цэгийн байршил нь талууд өөрөөр тогтоогүй бол дараах байршилд байна.
- 4.2.1. МХС 2 давхар, Дата центрийн өрөө;
- 4.2.2. МХС шахтын өрөө.
- 4.3. Телефон ярианы үйлчлэгч нь Харилцаа холбооны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу харилцаа холбооны

- үйлчлэгчийн сүлжээнд харилцан холболт хийх цэг хүртэл шаардагдах хөрөнгө оруулалтыг хариуцна.
- 4.4. Энэхүү нөхцөлийн 4.3 дэх хэсэгт заасан хөрөнгө оруулалтыг харилцаа холбооны үйлчлэгч хариуцаж болох бөгөөд ямар тохиолдолд хариуцах талаар энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйл сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагад нарийн, тодорхой тусгасан байна.
- 4.5. Талууд үйлчилгээний чанарын шаардлагыг хангах үүднээс тус тусын хариуцаж буй зааглах цэг хүртэлх сүлжээ, дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд энэхүү нөхцөлийн долдугаар зүйлд заасан гэрээний загварт дангаар эсхүл харилцан тусгай нөхцөл тогтоож болно.
- 4.6. Сүлжээний зааглах цэгүүдийн байршлыг энэхүү нөхцөлийн хавсралт 1-т зургаар дэлгэрүүлэн заана.
- 4.7. Хэрвээ хүсэлт гаргагч нь Хавсралт 1-т зааснаас өөр байршилд сүлжээнд холбогдох, шинээр зааглах цэг тогтоолгох хүсэлтэй бол 2 тал техникийн нөхцөл дээр харилцан хэлэлцэж, боломжит нөхцөл байгаа эсэх талаарх дүгнэлтийг Зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 4.8. Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
- 4.9. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замуудыг гэрээний хавсралтаар зааж өгнө.
- 4.10. Зааглах цэгээс хоёр тийш тус тусын техник, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг холбогдох талууд хариуцана.

5. СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТӨЛБӨР ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

- 5.1. Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох төлбөрийг журмын 8 дугаар зүйлд заасны дагуу тогтоож, энэхүү зүйлд нарийвчлан тусгана.
- 5.2. Харилцаа холбооны үйлчлэгч нь үйлчилгээний үнэ тарифаа өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээллэнэ.
- 5.3. Ашиглалт үйлчилгээний болон сүлжээнд харилцан холболт хийх төлбөрийг энэхүү нөхцөлийн 7.1 дэх хэсэгт заасан гэрээнд тусгаж зохицуулна.
- 5.4. Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 5.5. Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна.
- 5.6. Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлд тусгагдах сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох төлбөр болон сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг дараах байдлаар тогтооно. Үүнд:
- 5.6.1. Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд оролцогч талууд нь сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний төсөлд тусгах сүлжээ хооронд харилцан холболт хийх төлбөр болон сүлжээ хоорондын

харилцан холболтын орлого хуваарилах зарчмын тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиролцоонд хүрээгүй бол тус тусын саналыг, үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд илгээнэ.

- 5.6.2. Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний төсөлд тусгах сүлжээнд холбогдох төлбөрийн тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиолцоогүй бол тус тусын саналыг, үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд илгээнэ.
- 5.7. Шаардлагатай тохиолдолд харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээний төрөл болон онцлогоос үл хамааран гэрээнд тусган мөрдөх сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр болон орлого хуваарилах зарчмыг Зохицуулах хорооны шийдвэрийн дагуу гэрээнд тусгаж, сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг байгуулах үүрэгтэй.
- 5.8. Талууд гэрээний үйлчилгээний харилцан холболтын төлбөрийг гэрээний хавсралтаар зааж өгөх бөгөөд төлбөрийг сар бүр хийнэ.
- 5.9. Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдсэн байна.
- 5.10. Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг 1 /нэг/ секундийн алхамтайгаар тооцно.
- 5.11. Талуудын төлбөр тооцооны төвийн ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш 6 хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, 8 хоногт багтаан тооцоог харилцан холболтын орлого хуваарилах зарчмын дагуу цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.12. Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн $\pm 1\%$ -тай тэнцэх хэмжээнээс хэтрэхгүй бол талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн $\pm 1\%$ -тай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр гэрээнд заасан хугацаанд багтаан нийлж, гарсан зөрүүг талуудын төлбөр тооцооны төвийн ажилтнууд дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж, дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 5.13. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог гэрээний 5.5-д заасан хугацаанаас хойш ажлын 3 хоногт багтаан нийлж, илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба төлбөр хариуцагч тал нь нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг НӨАТ-ын хамт төлнө.
- 5.14. Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 5.15. Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг ачааллын чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 5.16. Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.17. Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь гэрээний хавсралтад дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд талуудын холбох шугамаар орж ирсэн л бол тухайн ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.

- шугамаар орж ирсэн л бол тухайн ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 5.18. Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн дүнгийн 5%-ийг тус тусын талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.19. Аль нэг тал өөрийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

6. ГЭРЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 6.1. Телефон ярианы үйлчлэгч харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох хүсэлтээ журмын 3.1⁴ дэх хэсэгт заасан хэлбэрээр гаргах бөгөөд уг хэлбэрээс бусад хэлбэрээр гаргасан аливаа хүсэлтийг шийдвэрлэхгүй.
- 6.2. Телефон ярианы үйлчлэгч харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох хүсэлтдээ дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:
- 6.2.1. Сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил;
- 6.2.2. Холболт хийх гэж буй төхөөрөмжийнталаар мэдээлэл;
- 6.2.3. Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим мэдээлэл;
- 6.2.4. Энэхүү нөхцөлийн гуравдугаарт зүйлд тусгасан гэрээний нөхцөлийг хангах талаар бусад мэдээлэл зэрэг болно.
- 6.3. Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл олгох боломжийг судлах зорилгоор энэхүү нөхцөлийн 6.2 дахь хэсэгт зааснаас гадна байгууллагын нууцад хамаарахгүй нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 6.4. Харилцаа холбооны үйлчлэгч нь энэхүү нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан хэлбэрээс өөр хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдлийг бичгээр мэдэгдэнэ.
- 6.5. Харилцаа холбооны үйлчлэгч нь телефон ярианы үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй этгээдээс бусад этгээд сүлжээнд холбогдох хүсэлт ирүүлсэн тохиолдолд Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлнэ.
- 6.6. Харилцаа холбооны үйлчлэгч нь телефон ярианы үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдөр, цаг, минутаар шүүж, түрүүлж ирснийг нь эхэнд шийдвэрлэх зарчим баримтлана.
- 6.7. Харилцаа холбооны үйлчлэгч нь энэхүү нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйл сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж, журмын 3.2⁵ дахь хэсэгт заасан хэлбэр, хугацаанд хариу мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг техникийн нөхцөл гэж ойлгоно.
- 6.8. Харилцаа холбооны үйлчлэгч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчид техникийн нөхцөл гаргах боломжгүй болсон тохиолдолд журмын 3.3⁶ дахь хэсэгт заасны дагуу хариу хүргүүлэх бөгөөд уг

⁴ Харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг харилцаа холбооны үйлчлэгчид бичгээр гаргана.

⁵ Харилцаа холбооны үйлчлэгч нь уг хүсэлтийг хүлээн авч өөрийн сүлжээний техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж буй эсэхийг нягталж, өөрийн сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 10 хоногийн дотор хариуг хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ.

⁶ Харилцаа холбооны үйлчлэгч нь техникийн нөхцөл гаргах боломжгүй бол хүсэлт гаргагч талд тухайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болох хугацааг тодорхой дурдсан холбогдох тайлбарыг хүргүүлэх ба хувийг Зохицуулах хороонд заавал ирүүлнэ.

хариу тайлбартаа техникийн нөхцөл олгох боломжгүй үндэслэлийг тодорхой дурдана.

- 6.9. Телефон ярианы эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн тусгай зөвшөөрөл нь хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд харилцаа холбооны үйлчлэгчээс олгогдсон техникийн нөхцөл хүчингүй болно.
- 6.10. Харилцаа холбооны үйлчлэгч нь журмын 4.3⁷ хэсэгт заасан бүртгэлийн гэрчилгээ авсан этгээдийг өөрийн сүлжээндээ холбох эсэхийн Зохицуулах хороотой зөвшилцөж шийдвэрлэнэ.

7. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

- 7.1. Харилцаа холбооны үйлчлэгч нь Харилцаа холбооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1⁸ дэх хэсэгт зааснаар холбогдох үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийг өөрийн сүлжээндээ холбохдоо гэрээ байгуулна.
- 7.2. Энэхүү нөхцөлийн 7.1 дэх хэсэгт заасан гэрээг сүлжээнд холбогдох болон сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулна. Сүлжээний ашиглалт, үйлчилгээг зохицуулахаар тусдаа гэрээ байгуулахыг хориглоно.
- 7.3. Харилцан холболт хийх гэрээний төслийг холбогдох хууль тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан шийдвэр, зохицуулалт, нөхцөл шаардлага, журамтай нийцүүлэн боловсруулж энэхүү нөхцөлд хавсарган цахим хуудасдаа хамтад нь байршуулна.
- 7.4. Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний төслийг боловсруулахдаа энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйлд заасан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагыг салшгүй хэсэг болгоно.
- 7.5. Энэхүү нөхцөлийн 7.3 дахь хэсэгт заасан гэрээний салшгүй хэсэгт сүлжээнд холболт хийж буй телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн хүсэлтээр хууль болон Зохицуулах хорооноос баталсан журам, нөхцөл шаардлага, шийдвэрээр хязгаарласан асуудлаас бусад асуудлаар харилцан тохиролцон өөрчлөлт оруулах боломжтой байна. Бусад тохиолдолд энэхүү нөхцөлийн гуравдугаар зүйлд зааснаас өөрөөр гэрээнд оруулахыг хориглоно.
- 7.6. Харилцаа холбооны үйлчлэгч нь телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн техникийн нөхцөл энэхүү нөхцөлийн 6.10 дахь хэсэгт зааснаар хүчингүй болсон тохиолдолд сүлжээний холболтыг салгах арга хэмжээ авч, Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх бөгөөд сүлжээнд холбогдох гэрээндээ уг нөхцөлийг хэрэгжүүлэх заалтыг заавал тусгана.
- 7.7. Харилцаа холбооны үйлчлэгч болон телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нь сүлжээний ашиглалт, үйлчилгээг журмын 7.2⁹ дахь хэсэгт зааснаас өөрөөр хариуцах тохиолдолд гэрээндээ энэ талаар тодорхой тусгана.

⁷ Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу бүртгэл хийлгэсэн иргэн, хуулийн этгээд нь бүртгэлийн гэрчилгээ авснаас хойш 3 сарын дотор холболтоо хийж эхлээгүй бол техникийн нөхцөл хүчингүй болно.

⁸ Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр зохицуулна.

⁹ Талууд сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцна.

7.8. Журмын 7.3¹⁰ дахь хэсэгт заасан сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд тохиролцон гэрээндээ тусгана.

8. ГОМДОЛ ГАРГАХ

8.1. Энэхүү нөхцөлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар журмын 10.1¹¹ дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

– о О о –

¹⁰ Сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцон тогтоох ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

¹¹ Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг зорих бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 31.2 заалтын дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

Харилцан холболт хийх гэрээний
ерөнхий нөхцөл /RIO/-ийн 1-р хавсралт



**ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ**


Үзүүлэлт	Ондо ХХК
Холболтын байгууламжийн төрөл, марк	IMS
Дамжуулах байгууламжийн төрөл, марк, багтаамж	1.IP /switch/ 2.SIP /switch/
Холбох шугамын төрөл, марк, багтаамж	1. 100M 2. 1G 3. 10G
Интерфейсийн төрөл	1. Electrical ethernet 2. Optical ethernet

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Үзүүлэлт	Байршил
Зааглах цэгийн байршил	1. МХС 2 давхар, Дата центрийн өрөө 2. МХС шахтын өрөө
Тоног төхөөрөмж	Cisco2900 /switch/
Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг хэн хариуцах	Зааглах цэгээс өөрийн талын төхөөрөмжийг талууд өөрсдөө хариуцна


СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Зааглах цэгийн зураглал



○ Зааглах цэг 1


Зааглах цэгийн зураглал




○ Зааглах цэг 2

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН МЕССЕЖИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Зааглах цэгийн зураглал



Зааглах цэгийн зураглал



Харилцан холболт хийх гэрээний
ерөнхий нөхцөл /RIO/-ийн 2-р хавсралт

**ОНДО ХХК БОЛОН ХХК-ИЙН СҮЛЖЭЭ
ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ**



2022 оны ...-р сарын-ний өдөр

№

Улаанбаатар хот

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ нь /цаашид “Гэрээ” гэх/ Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд /Regulatory Principles Reference Paper (RPRP)/, Монгол Улсын холбогдох хууль, Харилцаа холбооны тухай Монгол Улсын хууль, Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/-оос батлагдан гарсан харилцан холболтын талаарх холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэсэн болно.

Нэг талаас: “Ондо” ХХК /цаашид “Ондо” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал ...,

Нөгөө талаас: ХХК /цаашид “.....” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал /цаашид хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх/ нар доорх нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Талууд өөрийн сүлжээний хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор нөгөө талын сүлжээтэй харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.
- 1.2. Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3. Талууд Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталж гаргасан “Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4. **Гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:**
 - 1.4.1. Үндсэн хэсэг
 - 1.4.1.1. Ерөнхий зүйл
 - 1.4.1.2. Талуудын эрх, үүрэг
 - 1.4.1.3. Техникийн нөхцөл
 - 1.4.1.4. Ашиглалт үйлчилгээ
 - 1.4.1.5. Төлбөр тооцоо
 - 1.4.1.6. Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх тухай
 - 1.4.1.7. Хариуцлага
 - 1.4.1.8. Маргаан шийдвэрлэх

- 1.4.1.9. Гэрээний үйлчлэх хугацаа
- 1.4.1.10. Давагдашгүй хүчин зүйл
- 1.4.1.11. Бусад
- 1.4.2. Хавсралт 1. Техник төхөөрөмжийн жагсаалт, үзүүлэлт, зааглах цэг
- 1.4.3. Хавсралт 2. Харилцан холболтын зураглал
- 1.4.4. Хавсралт 3. Талуудын сүлжээний дугаарлалт
- 1.4.5. Хавсралт 4. Харилцан холболтын орлого хуваарилах зарчим
- 1.4.6. Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн хаяг, холбоо барих арга хэрэгсэл
- 1.5. Гэрээний талууд дараах харилоцан холболтын үйлчилгээг үзүүлнэ.**
 - 1.5.1. Дотоод дуудлага хүлээн авах
 - 1.5.2. Дотоод дуудлага хийх
 - 1.5.3. Улс хоорондын дуудлага хүлээн авах
 - 1.5.4. Улс хоорондын гарах дуудлага хийх
 - 1.5.5. Дотоод мессеж бичих
 - 1.5.6. Дотоод мессеж хүлээн авах
- 1.6. Гэрээний хүрээнд талууд дараах транзит үйлчилгээг үзүүлнэ.**
 - 1.6.1. Дуудлага дамжуулах
 - 1.6.2. Мессеж дамжуулах
- 1.7. 1Талууд-ны сүлжээгээр дамжуулан (транзит хийх) холболт хийх ба талуудын-тай байгуулсан харилцан холболтын гэрээг үндэслэл болгоно.**
- 2. Талуудын эрх, үүрэг**
 - 2.1. Талууд дор дурдсан эрхийг эдэлнэ.**
 - 2.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих буюу шударга ёсоор биелүүлэхийг нөгөө талаас шаардах.
 - 2.1.2. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах тухай санал гаргах.
 - 2.1.3. Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах.
 - 2.1.4. Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах.
 - 2.1.5. Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулах.
 - 2.1.6. Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 7 дугаар зүйлд заасан хариуцлагын арга хэмжээг шат дараатайгаар хэрэглэх.
 - 2.2. Талууд дор дурдсан үүргийг хүлээнэ.**
 - 2.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх.
 - 2.2.2. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх.
 - 2.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талынхаа бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх.
 - 2.2.4. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг холбогдох баримт, нотолгоог үндэслэн тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх.
 - 2.2.5. Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх.
 - 2.2.6. Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол Зохицуулах хороо-д 72 цагийн өмнө, өөрийн

сүлжээний болон гэрээнд оролцогч талын хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх.

- 2.2.7. Талууд гэрээ байгуулах, хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан нөгөө талын бизнесийн эсхүл хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээлэл баримт (дотоод зохион байгуулалт, техникийн шийдэл, хамгаалалт, аюулгүй байдал гэх мэт)-ийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол, эсвэл түүний эсрэг ашиглахгүй, бүх хэлбэрээр бусдад задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хуцаагүй хүлээнэ.

3. Техникийн нөхцөл

3.1. Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт

- 3.1.1. Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл, интерфэйсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байх ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгаж байна.
- 3.1.2. Сүлжээ хоорондын дохиолол нь SIP байна.
- 3.1.3. Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.

3.2. Зааглах цэг

- 3.2.1. Сүлжээний зааглах цэгүүдийн байршил Хавсралт 1-д заасны дагуу байна.
- 3.2.2. Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
- 3.2.3. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 3.2.4. Талууд зааглах цэгээс хоёр тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

3.3. Сүлжээний ачаалал

- 3.3.1. Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
- 3.3.2. Нэгж шугамд ноогдох ачааллын хэмжээг 0.65 Эрлангаас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.3.3. Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талуудын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг 3 сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

3.4. Дугаарлалт

- 3.4.1. Талуудын сүлжээний дугаарлалт нь Зохицуулах хороо-оос олгогдсон дугаарлалтын хүрээнд Хавсралт 3-д заасны дагуу байна.
- 3.4.2. Талууд сүлжээний дугаар шинээр үүсгэх тохиолдолд нөгөө талдаа ажлын 5 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 3.4.3. Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах үүрэгтэй. Энэ нь улс хооронд болон улс доторх телефон ярианд ижил хамаарна.

4. Ашиглалт үйлчилгээ

- 4.1. Түрээсийн шугам ашиглахаас бусад тохиолдолд зааглах цэгээс хоёр тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл саатлын засварыг хариуцна.
- 4.2. Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг 7 хоногийн өмнө урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 4.3. Талууд харилцан холболтын телефон ярианы өгөгдлүүд нь талуудын төлбөр тооцооны системд зөв ажиллаж байгаа талаар жил бүрийн эхний улиралд багтаан тест хийн баталгаажуулж, протокол үйлдэж байна.
- 4.4. Аль нэг тал нь нөгөө талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Гарсан гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 4.5. Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг Талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус халдлага /fraud/-д өртөх тохиолдолд тухайн Тал нь нөгөө Талд учирсан хохирлыг бүрэн барагдуулна.
- 4.6. Талууд сүлжээний ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих арга хэрэгсэл зэргийг Гэрээний Хавсралт 5-д заасан байна.

5. Төлбөр тооцоо

- 5.1. Талууд гэрээний 1.6-д заасан үйлчилгээний харилцан холболтын төлбөрийг Хавсралт 4-д заасан нөхцөлийн дагуу сар бүр хийнэ.
- 5.2. Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдсэн байна.
- 5.3. Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг 1 /нэг/ секундйн алхамтайгаар тооцно.
- 5.4. Талуудын төлбөр тооцооны төвийн ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш 6 хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, 8 хоногт багтаан тооцоог Хавсралт 4-д заасан харилцан холболтын орлого хуваарилах зарчмын дагуу цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.5. Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн +/-1%-тай тэнцэх хэмжээнээс хэтрэхгүй бол талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн +/-1%-тай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр гэрээний 5.5-д заасан хугацаанд багтаан нийлж, гарсан зөрүүг талуудын төлбөр тооцооны төвийн ажилтнууд дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж, дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 5.6. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог гэрээний 5.5-д заасан хугацаанаас хойш ажлын 3 хоногт багтаан нийлж, илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба төлбөр хариуцагч тал нь нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг НӨАТ-ын хамт төлнө.

- 5.7. Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 5.8. Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг ачааллын чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 5.9. Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.10. Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь Хавсралт 3-д дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд талуудын холбох шугамаар орж ирсэн л бол тухайн ачааллыг талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 5.11. Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн дүнгийн 5%-ийг тус тусын талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.12. Аль нэг тал өөрийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.13. Гэрээний 5.7-д заасны дагуу илүү төлөлттэй талдаа харилцан холболтын төлбөрийн нэхэмжлэхийг тухайн цаг хугацаанд гаргаагүй нь төлбөрийг шаардах эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

6. Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх

- 6.1. Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 /арав/ өдрийн дотор хүсэлт гаргасан талд гаргаж өгнө. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 6.2. Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүр аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 6.3. Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө талын сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө талдаа тухай бүр ажлын 5 /тав/ хоногийн өмнө мэдэгдэх ба хүлээж авсан тал ажлын цар хэмжээнээс хамааран гүйцэтгэх хугацааг тохирон хэрэгжүүлнэ. Жич: Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 6.4. Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

7. Хариуцлага

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх, эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд нөгөө талд хохирол учруулсан нь нотлогдсон тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 7.2. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа зохих ёсоор биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах дор дурьдсан аргыг шат дараатайгаар хэрэглэнэ.
 - 7.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлэх.
 - 7.2.2. Гэрээний 7.3-д заасан нөхцөлийн дагуу алданги тооцох.

- 7.2.3. Аль нэг тал нь харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн тохиолдолд гэрээний заалтыг хэрэгжүүлэн харилцан холболтын хязгаарлалт, салгалтыг хийх.
- 7.3. Алдангийг дор дурьдсан нөхцөлд тооцно.
- 7.3.1. Аль нэг тал гэрээний 5.7-д заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн.
- 7.3.2. Аль нэг талын аливаа алдаа эсвэл буруутай үйлдлээс шалтгаалж харилцан холболтын тооцоог гэрээний 5.5-д заасан хугацаанд багтаан нийлээгүйн улмаас гэрээний 5.7-д заасан төлбөр төлөх хугацаа хойшилсон.
- 7.3.3. Аль нэг тал энэ гэрээ болон хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцан холболтын тооцоог нийлээгүй, нийлэхийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас гэрээний 5.7-д заасан хугацаа хэтэрсэн.
- 7.4. Алданги нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.3 хувь байна.
- 7.5. Талууд гэрээний 7.2-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг шат дараатайгаар хэрэглэж эхэлснээр буруутай тал 30 хоногийн дотор гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал гэрээг дангаар цуцлах ба энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.
- 7.6. Гэрээний 7.2-т заасан арга хэмжээг хүлээсэн нь талуудыг гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхгүй байх болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүй.
- 7.7. Талууд гэрээний хүрээнд олж авсан төрийн болон албан байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах үүрэг хугацаагүй хүлээх ба тухайн нууц мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах үүрэг хугацаагүй хүлээх ба тухайн нууц мэдээллийг задруулах, бусдад дамжуулах, нийтэд ил болгохыг хориглоно.

8. Маргаан шийдвэрлэх

- 8.1. Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг Зохицуулах хороо-д хандаж шийдвэрлүүлнэ.
- 8.2. Зохицуулах хороо-оос гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, эсвэл Зохицуулах хороо хуульд заасан хугацаанд шалгаж хариу өгөөгүй бол талууд шүүхэд хандах эрхтэй.

9. Гэрээний үйлчлэх хугацаа

- 9.1. Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээ 2022 оны 02-р сарын-ний өдрөөс эхлэн / / жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг ижил нөхцөлөөр нэг жилийн хугацаатайгаар сунгагдсанд тооцно.
- 9.3. Талууд 7.5-д зааснаас бусад тохиолдолд гэрээг харилцан тохиролцож цуцалж болох ба гэрээнд заасан нөхцөлөөс бусад тохиолдолд гэрээг аль нэг тал дангаараа цуцлахыг хориглоно. Талуудын аль нэг нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ нөгөө талдаа 2 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.

10. Давагдашгүй хүчин зүйл

- 10.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь 1 сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 10.4. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

11. Бусад

- 11.1. Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 11.2. Талууд харилцан хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй.
- 11.3. Аль нэг тал энэ гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаварыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 11.4. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 11.5. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор гэрээг хавсралтуудын хамт Зохицуулах хороо-д хүргүүлнэ. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг тухай бүр Зохицуулах хороо-д хүргүүлж байна.
- 11.6. Талуудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, өмчлөл өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран гэрээний 9.1, 9.2-т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 11.7. Гэрээнд хоногоор илэрхийлэгдсэн хугацааг “ажлын” гэж тодотгоогүй тохиолдолд хуанлийн хоногоор тооцно.

Талуудын албан ёсны хаяг:

Ондо ХХК:

14120 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

..... **ХХК:**

..... Улаанбаатар хот,
..... дүүрэг, 1-р хороо,

Олимпийн гудамж, Нью Хоризонс
барилгын 2 давхарт, 201 тоот

Бүртгэлийн гэрчилгээ: 9019097267
Регистрийн дугаар: 6175015
Утас: 72110101
Факс: -

..... байр,-р
давхар, тоот

Бүртгэлийн гэрчилгээ:
Регистрийн дугаар:
Утас:
Факс:

Гэрээ байгуулсан:

*Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч
байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.*

ОНДО ХХК -ийг төлөөлж:

..... ХХК-ийг төлөөлж:

.....

.....

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Харилцан холболт хийх гэрээний
ерөнхий нөхцөл /RIO/-ийн 3-р хавсралт




ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ


Харилцан холболтыг гэрээ байгуулах процесс	Хугацаа
Гэрээ байгуулах хүсэлт гаргах, хүлээн авах: (Хүсэлтэд ХХЗХ-ноос дугаар олгосон гэрээ, тусгай зөвшөөрлийн хуулбар, холбоо бүхий ажилтнуудын и-мэйл хаяг, холбоо барих дугаар зэрэг мэдээллийг хавсаргана.)	Тухай бүр
Талууд шаардлагатай тохиолдолд харилцан холболтын талаарх бизнесийн нууцад хамаарахгүй асуудлаар нэмэлт мэдээлэл шаардах	Албан ёсоор хүсэлт өгсөн өдрөөс 2 хоногийн дотор
Гэрээний нөхцөл хангаж буй эсэхийг нягталж, санал дүгнэлт гаргах:	Нэмэлт мэдээлэл шаардсан бол түүнийг ирсэн өдрөөс, бусад тохиолдолд хүсэлт ирсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор дүгнэлтийг нөгөө талд мэдэгдэнэ.
• Техникийн нөхцөл хангаж байгаа эсэхийг технологийн албаны саналаар	
• Эдийн засгийн нөхцөл хангаж байгаа эсэхийг бизнес санхүүгийн асуудал эрхэлсэн албаны саналаар	
• Гэрээ хэлбэрийн болон хуулийн шаардлага хангаж байгаа эсэх талаар	
Гэрээ хийх техник эдийн засгийн боломжгүй тохиолдолд тайлбар бүхий албан бичгийг хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.	Санал дүгнэлт гарсанаас хойш ажлын 3 хоногт
Гэрээ байгуулах боломжтой гэж үзвэл • Харилцан холболтын тест хийнэ • 2 тал акт үйлдэнэ	Санал дүгнэлт гарсанаас хойш ажлын 30 хоногт
Талууд гэрээнд гарын үсэг зурах	Акт хүлээлцсэнээс хойш ажлын 5 хоногт
Харилцан холболтын гэрээг Зохицуулах хороонд хүргүүлэх	Харилцан холболтын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор
Харилцан холболтын гэрээний нэмэлт өөрчлөлтийг Зохицуулах хороонд бүртгүүлэх	Тухай бүр

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН МЕССЕЖИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Зааглах цэгийн зураглал



Зааглах цэгийн зураглал



Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний
Хавсралт 1



ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Ондо ХХК	 ХХК
Холболтын байгууламжийн төрөл, марк	IMS	
Дамжуулах байгууламжийн төрөл, марк, багтаамж	1.IP /switch/ 2.SIP /switch/	
Холбох шугамын төрөл, марк, багтаамж	1. 100M 2. 1G 3. 10G	
Интерфейсийн төрөл	1. Electrical ethernet 2. Optical ethernet	

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Үзүүлэлт	Байршил	Тайлбар
Зааглах цэгийн байршил	1. МХС 2 давхар, Дата центрийн өрөө 2. МХС шахтын өрөө	
Тоног төхөөрөмж	switch	
Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг хэн хариуцах	Зааглах цэгээс өөрийн талын төхөөрөмжийг талууд өөрсдөө хариуцна	


Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
тоот гэрээний
Хавсралт 2



СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ


СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Зааглах цэгийн зураглал



○ Зааглах цэг 1

Зааглах цэгийн зураглал



○ Зааглах цэг 2

Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
тоот гэрээний
Хавсралт 3



ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

ОНДО ХХК-ИЙН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	81-11-xxxx
	81-66-xxxx
	81-81-xxxx
	81-88-xxxx
	60-xx-xxxx
	66-xx-xxxx

.....-ИЙН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
Үүрэн холбоо	
Улс хоорондын ярианы гарц	

Хавсралт баталсан:

ОНДО ХХК -ийг төлөөлж:

..... ХХК-ийг төлөөлж:

.....
Гүйцэтгэх захирал

.....
Гүйцэтгэх захирал

Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний
Хавсралт 4-1



ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ					
Улс доторх ярианы харилцан холболтын үнэ					
Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	-д	Ондо-д
.....-оос Ондо -руу	Үүрэн	Суурин		Баланс	
Ондо-оос- руу	Суурин	Үүрэн	Ондо	 төг	Баланс

Улс доторх мессежийн харилцан холболтын үнэ

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	-д	Ондо-д
.....-оос Ондо-руу	Үүрэн	Суурин		Баланс	
Ондо-оос- руу	Суурин	Үүрэн	Ондо		Баланс

Улс хоорондын ярианы харилцан холболтын үнэ

Чиглэл	Хаанаас		Хаашаа		Тариф	-д	Ондо-д
.....-аас Ондо-руу	Гадаад	 гарцаар	Монгол	Суурин	...	Баланс	 төг
Ондо-оос руу	Монгол		Гадаад				 төг

МК –-ны тухайн үйлчилгээний тариф;
УХ 1 –-ны улс хоорондын 001 гарцын тариф;
Ондо–Ондо-ын тухайн үйлчилгээний тариф;

Хавсралт баталсан:

Ондо ХХК -ийг төлөөлж:

..... ХХК-ийг төлөөлж:

.....
Гүйцэтгэх захирал

.....
Гүйцэтгэх захирал

Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний
Хавсралт 4-2

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТООЦОО НИЙЛЭХ МАЯГТ

Тооцоонд хамаарах хугацаа				
Ондо-гоос □ руу	тариф	дуудлага	хугацаа /мин/	Төлбөр
Яриа				
Ондо-гоос-лын үүрэн рүү				
Ондо-гоос-ын 009 гарцаар гарсан				
.....-лын 009 гарцаар-д төгссөн				
Мессеж				
Ондо-гоос- руу мессеж илгээсэн				
.....-д нийт төлөх				
.....-аас □ Ондо руу	тариф	дуудлага	хугацаа /мин/	Төлбөр
Яриа				
.....-лаас Ондо-гийн үүрэн рүү				
.....-аас 009 гарцаар Ондо-гийн үүрэн рүү төгссөн				
Мессеж				
.....-аас Ондо руу мессеж илгээсэн				
Ондо-д нийт төлөх				
Тооцоо нийлсэн				
.....-ыг төлөөлж:		инженер		
Ондо-г төлөөлж:		инженер		

Хавсралт баталсан:

Ондо ХХК -ийг төлөөлж: ХХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Ондо ХХК, ХХК-ийн
Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний
Хавсралт 5

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ**

“.....” ХХК-ийн албан тушаалтан холбоо барих арга хэрэгсэл

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

“Ондо” ХХК-ийн албан тушаалтан холбоо барих арга хэрэгсэл

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар	Захиргааны алба	Ерөнхий менежер	
		Хуульч	
Техникийн асуудлаар	Техникийн алба	Захирал	
		Холбох байгууламжийн инженер	
		Техникийн төлөвлөлтийн менежер	
Төлбөр тооцооны асуудлаар	Техникийн алба	Биллинг инженер	
	Санхүүгийн алба	Нягтлан бодогч	